ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 04-ний өдөр | Дугаар А/276 | Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7 дахь хэсэг, 268^1 дугаар зүйлийн 268^1.1.1 дэх заалт, 269^1 дүгээр зүйлийн 269^1.1.1 дэх заалт, 270^1 дугаар зүйлийн 270^1.1.4 дэх заалт, 271^1 дүгээр зүйлийн 271^1.1.1, 271^1.1.2 дахь заалт, Мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Гаалийн баталгаат агуулахын гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 1 дүгээр,

“Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 2 дугаар,

“Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 3 дугаар,

“Гаалийн баталгаат барилгын талбайн гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 4 дүгээр,

“Татваргүй барааны дэлгүүрийн гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 5 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2.Энэ журмыг гаалийн харилцаанд оролцогчдод сурталчлан таниулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн хэлтэс /С.Оюунцэцэг/, Гаалийн хяналт, шалгалтын газар /П.Баттөр/-т үүрэг болгосугай.

3.Шинэчлэн батлагдсан гаалийн бүрдүүлэлтийн горимын кодыг CAIS системийн ангилалтын санд оруулахыг Мэдээллийн технологийн төв /Б.Ганзориг/-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/42 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.АСРАЛТ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 4587 дугаарт бүртгэсэн.

Гаалийн ерөнхий газрын даргын
2019 оны А/276. дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ГААЛИЙН БАТАЛГААТ АГУУЛАХЫН ГОРИМ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гаалийн баталгаат агуулахын горим /цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө.

1.2.Горим сонгох, шаардагдах мэдээлэл бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3.Зөвшөөрөл авсан Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага Монгол Улсын Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлөөс баталсан агуулахын стандартын шаардлага хангасан байр, барилга байгууламж, задгай талбайд гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагааг эрхлэн явуулна.

1.4.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хуулийн этгээд нь хүсэлт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.4, Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасан бичиг баримтыг бүрдүүлнэ.

1.5.Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтийг гаалийн байгууллага хянахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан үзнэ**:**

1.5.1.тухайн нутаг дэвсгэрт гаалийн баталгаат агуулах байгаа эсэх**;**

1.5.2.үйл ажиллагаа явуулж байгаа агуулахын багтаамж, хүчин чадал, зориулалт нь бараа эргэлтийн ачааллыг дааж байгаа эсэх**;**

1.5.3.хяналт тавих гаалийн байгууллагын хүний нөөц, үйл ажиллагааны зардалд сөргөөр нөлөөлөх эсэх;

1.5.4.тухайн нутаг дэвсгэрт гаалийн баталгаат агуулах байгуулах хэрэгцээ шаардлага байгаа эсэх;

1.5.5.тухайн аж ахуйн нэгж баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхэлж байсан эсэх, Гаалийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.2-т заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл хүчингүй болсноос хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн эсэх.

1.6.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг гаалийн удирдах төв байгууллагын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

1.7.Гаалийн удирдах төв байгууллага Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.1.1-т заасны дагуу гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж, энэ журмын хавсралтаар батлагдсан загвар бүхий “Зөвшөөрөл” олгоно.

1.8.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгах, агуулахын зориулалт, агуулахын талбайн хэмжээ, байршил болон төрөл өөрчлөх, агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлөө хүчингүй болгуулах талаар өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

1.9.Хяналт тавих гаалийн байгууллага нь гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.10.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага “Өөрийн үнэлгээний хуудас” бөглөж, хяналт тавих гаалийн байгууллагаар хянуулж, баталгаажуулалт хийлгэсэн байна.

1.11.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргахдаа энэ журмын 1.9-д заасан гэрээг дүгнүүлэн, “Өөрийн үнэлгээний хуудас”-аас аль тохирохыг бөглөж, хяналт тавих гаалийн байгууллагаар хянуулж, баталгаажуулалт хийлгэсэн байна.

1.12.Хяналт тавьж байгаа гаалийн байгууллага нь “Өөрийн үнэлгээний хуудас”-ын дагуу тухайн баталгаат агуулахын үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр тус тус “Хангалттай” эсхүл “Хангалтгүй” гэсэн үнэлгээгээр үнэлж, дараа сарын 05-ны өдрийн дотор гаалийн хяналт, шалгалтын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

1.13.Гаалийн баталгаат агуулах эрхлэх зөвшөөрөл олгосон, зөвшөөрлийн хугацаа сунгасан тухай гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаал батлагдсанаас хойш ажлын 7 хоногт багтаан Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолын хавсралтын 9.1.7-д заасан улсын тэмдэгтийн хураамжийг төлнө.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Горимд Гаалийн тухай хуулийн 142 дугаар зүйлд заасан барааг байршуулна.

2.2.Горимд байршуулах монголын бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарах бөгөөд гадаадын бараа нь Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.

2.3.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг гаалийн баталгаат агуулахад оруулах	700	шаардахгүй
2	Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг гаалийн баталгаат агуулахад оруулах	701	шаардахгүй
3	Хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын барааг гаалийн баталгаат агуулахад оруулах	702	100, 101,110, 120, 131-134
4	Барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн баталгаат агуулахад оруулах :		
	-гаалийн баталгаат агуулахаас	703	700, 703
	-гаалийн тусгай бүсээс	704	750-753, 758-765
	-татваргүй барааны дэлгүүрээс	705	740, 742, 743
5	Барааг чөлөөт бүсээс гаалийн баталгаат агуулахад оруулах	706	770-771, 774-778
6	Гаалийн бусад хяналтад байгаа барааг гаалийн баталгаат агуулахад оруулах	707	шаардахгүй
7	Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг баталгаат агуулахад оруулах	708	910, 911
8	Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас гаалийн баталгаат агуулахад оруулах	709	720, 722-725

2.4.Гаалийн бүрдүүлэлтийн 703-707 болон 709 горимд гадаадын барааг байршуулна.

Гурав. Гаалийн бүрдүүлэлт

3.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас болон гаалийн баталгаат, чөлөөт бүсээс гаалийн баталгаат агуулахад оруулахад Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

3.2.Энэ горимын дагуу барааг гаалийн байгууллагад мэдүүлэхдээ тээврийн бичиг баримт, гадаад худалдааны гэрээ эсхүл үнийн нэхэмжлэхийг гаргаж өгнө.

3.3.Горимд байршуулах монголын бараанд гаалийн бүрдүүлэлт хийхэд Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан бичиг баримтыг гаргаж өгнө.

3.4.Журмын 3.2, 3.3-т заасан мэдээлэл, бичиг баримт нь горимын шаардлага хангахгүй бол гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.5.Мэдүүлэгч энэ журмын 3.4-т заасан бичиг баримтыг цахим шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.6.Гаалийн үнийг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу шалгаж тодорхойлно.

3.7.Горимын дагуу байршуулах барааны мэдээллийг хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч гаалийн автоматжуулсан системээр хүлээн авч, бичиг баримттай тулган шалгаж, “Баталгаажуулах” үйлдэл хийж, мэдээллийг гаалийн улсын ахлах байцаагчид гаалийн автоматжуулсан систем ашиглан цахимаар илгээнэ. Хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч “Зөвшөөрөх” үйлдэл хийсэнээр гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болно.

3.8.Мэдүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн мэдүүлгийг хэвлэж гаалийн улсын байцаагч баримтад “Гаалийн хяналтад байгаа” тэмдэг дарж, гаалийн улсын байцаагч гарын үсгээ зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.

Дөрөв. Горимын шаардлага

4.1.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэгч нь Гаалийн тухай хуулийн 145 дугаар зүйлд зааснаас гадна дараах нөхцөл шаардлагыг хангасан байна:

4.1.1.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон тушаалд заасан байршил, нутаг дэвсгэр, талбайд төрөл зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулах;

4.1.2.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь хяналт тавих гаалийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллах;

4.1.3.гаалийн байгууллагаас томилогдсон гаалийн ажилтныг ажлын байр болон ажиллах нөхцөлөөр хангах;

4.1.4.зөвшөөрөл бүхий даатгагчтай хариуцлагын даатгалын гэрээ байгуулсан байх;

4.1.5.тухайн үйл ажиллагаанаас эрсдэл үүссэн тохиолдолд гаалийн болон бусад татвар, хураамжийг төлж, барагдуулах санхүүгийн чадавхитай болохоо эрх бүхий аудитаар баталгаажуулсан сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, дансны хуулгаар нотолсон байх;

4.1.6.гаалийн баталгаат агуулах нь гаалийн нэгдсэн сүлжээнд холбогдож, барааны бүртгэлд GS1 системийг нэвтрүүлсэн байх;

4.1.7.тэгш өнцөгт хэлбэртэй 1.0х0.60 метрийн харьцаатай, цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн баталгаат агуулах” гэсэн бичээстэй, зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэг байрлуулсан байх;

4.1.8.барааг агуулахад байх хугацаанд гэмтсэн, муудсан, чанарын шаардлага хангахгүй болсон бол уг бараанд мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулж, гаалийн хууль тогтоомжийн дагуу гаалийн бүрдүүлэлт хийлгэх;

4.1.9.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэгч нь зөвшөөрөлд заасан байршил, төрөл, зориулалт, талбайн хэмжээг өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд шинэ талбайн хэмжээ, байрлал, барилга байгууламжийн зургийг холбогдох

бусад материалын хамт бүрдүүлж, гаалийн удирдах төв байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх;

4.1.10.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагааг задгай талбайд эрхлэх бол газар эзэмших гэрчилгээ, эсхүл газар эзэмшигчтэй байгуулсан түрээсийн гэрээ, газар өмчлөгчийн зөвшөөрөл авсан байх;

4.1.11.гаалийн баталгаат агуулахын барааны бүртгэлийг орсон, гарсан бараагаар хөтөлж, барааны хөдөлгөөний мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 03-ны дотор хяналт тавьдаг гаалийн байгууллагад өгөх;

4.1.12.бараг нэр төрлөөр нь ангилан байрлуулж, загвар бүхий шошго тавьж хадгалах;

4.1.13.гаалийн байгууллагатай гаалийн нэгдсэн онлайн сүлжээнд холбогдож, гаалийн хяналт, бүрдүүлэлтэд шинэ техник, технологи нэвтрүүлэн, Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажиллах;

4.1.14.гаалийн баталгаат агуулахад бараа ороогүй, хадгалагдаж байгаа бараа байхгүйгээр тасралтгүй 6 сар буюу түүнээс дээш хугацаа хэтрээгүй байх;

4.1.15.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хяналтын камерыг бараа бүхэлдээ харагдах, гаалийн хяналтын шаардлага хангахуйц тоо хэмжээгээр тохирох газарт байрлуулна. Камерын бичлэгийг гаалийн хяналтын зорилгоор ашиглах шаардлага хангахуйц түвшинд хийж, хяналтын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалж, гаалийн байгууллагаас шаардсан хугацаанд гаргаж өгөх;

4.1.16.хяналт тавьж ажиллах гаалийн байгууллагаас ирүүлсэн “Өөрийн үнэлгээний хуудас” нь 90 буюу түүнээс дээш хувиар “Хангалттай” үнэлэгдсэн байх.

4.2.Гаалийн байгууллага агуулахад хадгалах барааны онцлог байдлыг харгалзан тусгай нөхцөл шаардлага тавьж болно.

4.3.Агуулахад жижиглэнгийн худалдаа хийхгүй.

4.4.Гаалийн байгууллага нь гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр барьцааны болон улсын орлогын барааг гаалийн баталгаат агуулахад хадгалуулж болно.

4.5.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлт гаргана.

4.6.Агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч барааг энэ горимд байршуулах хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө мэдүүлэгч, эсхүл холбогдох этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

4.7.Барааг горимд байршуулах хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагын холбогдох нэгжид мэдүүлэгч эсхүл холбогдох этгээд бичгээр гаргана.

4.8.Энэ горимд байршуулсан барааг хоёр буюу түүнээс дээш гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс дамжуулан байршуулсан бол гаалийн баталгаат агуулахад байршуулах нийт хугацаа нь Гаалийн тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д заасан хугацаанаас хэтрэхгүй байна.

4.9.Гаалийн баталгаат агуулахаас бараа гаргахад бараа өмчлөх эрхийг шилжүүлж гаалийн бүрдүүлэлт хийж болно.

Тав. Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь агуулахад тавигдах горимын шаардлагыг зөрчсөн дараах тохиолдолд үйл ажиллагааг Гаалийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.1-д заасны дагуу 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно:

5.1.1.энэ журмын 4.1.1 дэх заалт, 4.1.9, 4.1.10, 4.1.13, 4.1.14, 4.1.15, 4.3 дахь хэсгийг зөрчсөн;

5.1.2.энэ журмын 1.12 дэх заалтад заасан үнэлгээний хуудсаар хангалтгүй үнэлэгдсэн тохиолдолд шаардлага хангуулах зорилгоор хяналт тавьж буй гаалийн байгууллагаас өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлээгүй;

5.1.3.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй нэвтрүүлсэн.

5.2.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шалтгаан, зөрчлийг арилгаж шаардлагыг заасан хугацаанд биелүүлсэн тохиолдолд зөвшөөрлийг сэргээх асуудлыг гаалийн удирдах төв байгууллага шийдвэрлэнэ.

5.3.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

5.3.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

5.3.2.зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан;

5.3.3.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

5.3.4.зөвшөөрөл эзэмшигч нь гаалийн тухай хууль тогтоомжийг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн.

5.4.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд энэ журмын 4.5-д заасны дагуу хүсэлт гаргаагүй, гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийг хүчингүй болгуулах хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж, зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.5.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ журмын 5.1, 5.3, 5.4-т заасны дагуу түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд тухайн гаалийн баталгаат агуулахад байршиж буй барааг Гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2.-т заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.

5.6.Энэ журмын 5.5-д заасан хугацаанд барааг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулаагүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Гаалийн болон бусад татвар

6.1.Гаалийн баталгаат агуулахад байршуулах болон тэндээс гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2-137.5, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

6.2.Агуулахын горимд байршуулсан барааны дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

6.2.1.давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар гаалийн баталгаат агуулахаас алдагдсан, устгагдсан;

6.2.2.энэ журмын 6.2.1-д зааснаас өөр бусад хэлбэрээр гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулсан.

6.3.Энэ журмын 6.2.-т заасан тохиолдолд импортын татварыг Монгол банкны ханшийг үндэслэн, хүчин төгөлдөр мөрдөж буй ердийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

Долоо. Бусад

7.1.Гаалийн баталгаат агуулахад байршуулах хугацаа хэтэрсэн барааг Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан журмын хавсралт

ЗӨВШӨӨРӨЛ

ДУГААР ...

_____

/Хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, оршин буй хаяг/

_____

/Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрөл/

_____

/Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа/

_____

/Гаалийн баталгаат бүсэд эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл шаардлага, код/

_____

/Зөвшөөрлийг олгосон тушаалын дугаар,он, сар, өдөр/

_____

/ гарын үсэг, тамга/

Зөвшөөрлийн ар талд хийх өөрчлөлт :

Зөвшөөрөлд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

№	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга, сунгалт	Бүртгэсэн	
		огноо	Гарын үсэг, тамга
1.			
2.			
3.			

Гаалийн ерөнхий газрын даргын
2019 оны А/276 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

ГААЛИЙН БАТАЛГААТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горим /цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө**.**

1.2.Горим сонгох, шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт дараах үйл ажиллагаа явуулна.

1.3.1.бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

1.3.2.материал, түүхий эдийг боловсруулах;

1.3.3.засвар үйлчилгээ хийх;

1.3.4.барааны дээж, сорьц, загвар авах;

1.3.5.гаалийн байгууллагаас зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа.

1.4.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагааг Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага холбогдох зөвшөөрлийн дагуу эрхлэн явуулна.

1.5.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хуулийн этгээд нь хүсэлт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.4, Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасан бичиг баримтыг бүрдүүлнэ.

1.6.Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтийг гаалийн байгууллага хянахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

1.6.1.Монгол Улсын Засгийн газраас батлагддаг тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтад хамрагдсан эсэх**;**

1.6.2.хяналт тавих гаалийн байгууллагын хүний нөөц, үйл ажиллагааны зардалд сөргөөр нөлөөлөх эсэх**;**

1.6.3.тухайн аж ахуйн нэгж баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхэлж байсан эсэх, Гаалийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.2-т заасан үндэслэлээр зөвшөөрөл хүчингүй болсноос хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн эсэх**;**

1.7.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг гаалийн удирдах төв байгууллагын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

1.8.Гаалийн удирдах төв байгууллага Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.1.2-т заасны дагуу гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж, энэ журмын хавсралтаар батлагдсан загвар бүхий “Зөвшөөрөл” олгоно.

1.9.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлөө хүчингүй болгуулах талаар талаар өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ**.**

1.10.Гаалийн хяналт тавих гаалийн байгууллага нь гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.11.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага “Өөрийн үнэлгээний хуудас”-ыг бөглөж, хяналт тавих гаалийн байгууллагаар хянуулж, баталгаажуулалт хийлгэсэн байна.

1.12.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргахдаа энэ журмын 1.10-т заасан гэрээг дүгнүүлэн, “Өөрийн үнэлгээний хуудас”-ыг бөглөж, хяналт тавьдаг гаалийн байгууллагаар хянуулж, баталгаажуулалт хийлгэсэн байна.

1.13.Хяналт тавьж байгаа гаалийн байгууллага нь гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагааг дүгнэхдээ “Хангалттай” эсхүл “Хангалтгүй” гэсэн үнэлгээгээр үнэлэх бөгөөд “Хангалтгүй” үнэлэгдсэн тохиолдолд гүйцэтгэл сайжруулж, шаардлага хангуулах зорилгоор тодорхой хугацаатай үүрэг өгч биелэлтэд хяналт тавина.

1.14.Хяналт тавьж байгаа гаалийн байгууллага нь “Өөрийн үнэлгээний хуудас”-ын дагуу тухайн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр тус тус “Хангалттай” эсхүл “Хангалтгүй” гэсэн үнэлгээгээр үнэлж, дараа сарын 05-ны өдрийн дотор гаалийн хяналт, шалгалтын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

1.15.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон, зөвшөөрлийн хугацаа сунгасан тухай гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаал батлагдсанаас хойш ажлын 7 хоногт багтаан Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолын хавсралтын 9.1.7-д заасан улсын тэмдэгтийн хураамжийг төлнө.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Горимд үйлдвэрлэл явуулахад шаардагдах үндсэн болон туслах материалыг байршуулна.

2.2.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйлдвэрлэл явуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмжийг энэ горимд байршуулахгүй бөгөөд мэдүүлэгчийн сонгосон бусад горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.3.Горимд байршуулах монголын бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарах бөгөөд гадаадын бараа нь Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.

2.4.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулах	710	шаардахгүй
2	Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулах	711	шаардахгүй
3	Барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулах:		
	- гаалийн баталгаат агуулахаас	712	700, 703, 704, 706, 707, 709
	-гаалийн баталгаат үйлдвэрийн газраас	713	710, 712, 714, 715
	-гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас	716	720- 725
	-гаалийн тусгай бүсээс	714	750-753, 758-765
4	Барааг чөлөөт бүсээс гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулах	715	770, 771, 774-778

2.5.Баталгаат үйлдвэрийн газрууд нь нэг эзэмшигчтэй бөгөөд гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулсан, эсхүл тэнд үйлдвэрлэсэн барааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн өөр гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулахад Гаалийн бүрдүүлэлтийн горимын 713 кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ.

Гурав. Гаалийн бүрдүүлэлт

3.1.Барарак гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас болон гаалийн баталгаат, чөлөөт бүсээс гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулахад Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

3.2.Энэ горимд байршуулах барарак гаалийн байгууллагад мэдүүлэхдээ Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан бичиг баримтаас гадна дараах бичиг баримтыг гаргаж өгнө:

3.2.1.үйлдвэрлэх бүтээгдэхүүн нь зах зээлд өрсөлдөх чадвартай болохыг нотлосон эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

3.2.2.технологийн бичиг баримт, түүнчлэн загвар, бараа тус бүрийн орц, материалын тооцоо;

3.2.3.шаардлагатай бусад бичиг баримт;

3.3.Журмын 3.2 дахь хэсэгт заасан мэдээлэл, бичиг баримт нь горимын шаардлага хангаагүй бол гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4.Мэдүүлэгч энэ журмын 3.3 дахь хэсэгт заасан бичиг баримтыг цахим шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.5.Мэдүүлэгч нь барарак үйлдвэрийн газарт боловсруулахтай холбогдсон мэдээллээр гаалийн байгууллагыг хангана. Тухайлбал: боловсруулах барарааны нэр, материалын орцын тооцоо, хаягдал болон үлдэгдэл барарааны хэмжээ, боловсруулалтын үр дүнд бий болох бүтээгдэхүүний загвар дээж, фото зураг, бүдүүвч зураг, худалдааны болон техникийн бичиг баримт, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлт, өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэх бол тухайн бүтээгдэхүүний мэдээлэл, схем, фото зураг гэх мэт.

3.6.Гадаад худалдааны гэрээнд барарак боловсруулах арга, үе шат, хугацаа, боловсруулалтын үйл ажиллагааны тухай нарийвчлан заасан байна.

3.7.Гадаадын барарак монголын бараатай нийлүүлж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, монголын барарак өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах бол материалын орцын норм хэмжээг тогтоосон байна.

3.8.Гаалийн хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч боловсруулалтанд ашиглагдсан барарааны тооцоог аж ахуйн нэгж, байгууллагатай нийлж, гаалийн бүрдүүлэлт хийхээс өмнө баталгаажуулсан байна.

3.9.Баталгаажуулсан материалын тооцоог үндэслэн зохих горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

3.10.Гаалийн үнийг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу нягтлан шалгана.

3.11.Горимын дагуу байршуулах барарааны мэдээллийг хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч гаалийн автоматжуулсан системээр хүлээн авч, бичиг баримттай тулган шалгаж, “Баталгаажуулах” үйлдэл хийж, мэдээллийг гаалийн улсын ахлах байцаагчид гаалийн автоматжуулсан систем ашиглан цахимаар илгээнэ. Хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч “Зөвшөөрөх” үйлдэл хийсэнээр гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болно.

3.12.Мэдүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн мэдүүлгийг хэвлэж гаалийн улсын байцаагч баримтад “Гаалийн хяналтад байгаа” тэмдэг дарж, гаалийн улсын байцаагч гарын үсгээ зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.

3.13.Үйлдвэрийн газарт боловсруулах барарааны боловсруулалтын явцад гарсан хаягдал, үлдэгдэл барааанд мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

Дөрөв. Горимын шаардлага

4.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт бараа оруулах, гаргах, боловсруулалт хийх явц, үйл ажиллагаа гаалийн хяналтад байна.

4.2.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэгч нь Гаалийн тухай хуулийн 152 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1.гаалийн байгууллагаас томилогдсон ажилтныг ажлын байр болон ажиллах нөхцөлөөр хангах;

4.2.2.гаалийн баталгаат үйлдвэрийн газрын орох, гарах хаалга, барилга байгууламж, объектыг дохиоллын найдвартай систем, байнгын гэрэлтүүлгээр тоноглож, телехяналтын систем бүхий харуул хамгаалалттай байх;

4.2.3.зөвшөөрөл бүхий даатгагчтай хариуцлагын даатгалын гэрээ байгуулсан байх;

4.2.4.тухайн үйл ажиллагаанаас эрсдэл үүссэн тохиолдолд гаалийн болон бусад татвар, хураамжийг төлж, барагдуулах санхүүгийн чадавхитай болохоо эрх бүхий аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, дансны хуулгаар нотолсон байх;

4.2.5.тэгш өнцөгт хэлбэртэй 1.0х0.60 метрийн харьцаатай, цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн баталгаат үйлдвэрийн газар” гэсэн бичээстэй, зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэг байрлуулсан байх;

4.2.6.гаалийн баталгаат үйлдвэрийн газар нь гаалийн нэгдсэн сүлжээнд холбогдож, барааны бүртгэлд GS1 системийг нэвтрүүлсэн байх;

4.2.7.барааг үйлдвэрийн газарт байх хугацаанд гэмтсэн, муудсан, чанарын шаардлага хангахгүй болсон бол уг барааг мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулж, гаалийн хууль тогтоомжийн дагуу гаалийн бүрдүүлэлт хийх;

4.2.8.гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хяналтын камерыг бараа, ажил, үйлчилгээ бүхэлдээ харагдах, гаалийн хяналтын шаардлага хангахуйц тоо хэмжээгээр тохирох газарт байрлуулна. Камерын бичлэгийг гаалийн хяналтын зорилгоор ашиглах шаардлага хангахуйц түвшинд хийж, хяналтын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалж, гаалийн байгууллагаас шаардсан хугацаанд гаргаж өгөх;

4.2.9.гаалийн баталгаат үйлдвэрийн газрын барааны орц нормын тооцоог гаргаж мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 03-ны дотор хяналт тавьдаг гаалийн байгууллагад гаргах өгөх;

4.2.10.гаалийн байгууллага бүтээгдэхүүний орц, норм хэмжээг хянаж тогтоох, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын туслалцаа авах;

4.2.11.гаалийн баталгаат үйлдвэрийн газарт бараа ороогүй, үйлдвэрлэл явуулахгүйгээр тасралтгүй 6 сар буюу түүнээс дээш хугацаа хэтрээгүй байх;

4.2.12.хяналт тавьж ажиллах гаалийн байгууллагаас ирүүлсэн “Өөрийн үнэлгээний хуудас” нь 90 буюу түүнээс дээш хувиар “Хангалттай” үнэлэгдсэн байх;

4.2.13.тухайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл учруулах тохиолдолд үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.3.Гаалийн байгууллага үйлдвэрийн газрын болон үйлдвэрлэл явуулж байгаа бараа бүтээгдэхүүний онцлог байдлыг харгалзан тусгай нөхцөл шаардлага тавьж болно.

4.4.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаргана.

4.5. Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч барааг энэ горимд байршуулах хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаалийн удирдах төв байгуулагын холбогдох нэгжид бичгээр гаргана.

Тав. Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь үйлдвэрийн газарт тавигдах горимын шаардлагыг зөрчсөн дараах тохиолдолд үйл ажиллагааг Гаалийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.1-д заасны дагуу 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно:

5.1.1.энэ журмын 4.1, 4.2.2, 4.2.7, 4.2.8, 4.2.11 дахь хэсгийг зөрчсөн;

5.1.2.энэ журмын 1.12 дахь заалтад заасан үнэлгээний хуудсаар хангалтгүй үнэлэгдсэнтэй холбогдуулж, шаардлага хангуулах зорилгоор хяналт тавьж буй гаалийн байгууллагаас өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлээгүй;

5.1.3.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй нэвтрүүлсэн.

5.2.гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шалтгаан, зөрчлийг арилгаж, шаардлагыг заасан хугацаанд биелүүлсэн тохиолдолд зөвшөөрлийг сэргээх асуудлыг гаалийн удирдах төв байгууллага шийдвэрлэнэ;

5.3.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

5.3.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

5.3.2.зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан;

5.3.3.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

5.3.4.зөвшөөрөл эзэмшигч нь гаалийн тухай хууль, тогтоомжийг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн.

5.4.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд энэ журмын 4.4-т заасны дагуу хүсэлт гаргаагүй, гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийг хүчингүй болгуулах хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж, зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.5.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ журмын 5.1, 5.3, 5.4-т заасны дагуу түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд тухайн гаалийн баталгаат үйлдвэрийн газарт байршиж буй барааг Гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2.-т заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.

5.6.Энэ журмын 5.5-д заасан хугацаанд барааг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулаагүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Гаалийн болон бусад татвар

6.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт байршуулах болон тэндээс гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2-137.5, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

6.2.Үйлдвэрийн газрын горимд байршуулсан бараанд дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулан хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

6.2.1.давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар гаалийн баталгаат үйлдвэрийн газраас алдагдсан, устгагдсан;

6.2.2.энэ журмын 6.2.1-д зааснаас өөр бусад хэлбэрээр гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулсан;

6.3.Энэ журмын 6.2.-т заасан тохиолдолд импортын татварыг Монгол банкны ханшийг үндэслэн, хүчин төгөлдөр мөрдөж буй ердийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

Долоо. Бусад

7.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт байршуулах хугацаа хэтэрсэн барааг Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/276 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан журмын хавсралт

ЗӨВШӨӨРӨЛ

ДУГААР ...

_____

/Хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, оршин буй хаяг /

_____

/Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрөл/

_____

/Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа/

_____

/Гаалийн баталгаат бүсэд эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл шаардлага, код/

_____

/Зөвшөөрлийг олгосон тушаалын дугаар,он, сар, өдөр/

_____

/ гарын үсэг, тамга/

Зөвшөөрлийн ар талд хийх өөрчлөлт :

Зөвшөөрөлд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

№	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга, сунгалт	Бүртгэсэн	
		огноо	Гарын үсэг, тамга
1.			
2.			
3.			

Гаалийн ерөнхий газрын даргын 2019
оны А/276 дугаар тушаалын
3 дугаар хавсралт

ГААЛИЙН БАТАЛГААТ ҮЗЭСГЭЛЭНГИЙН ГАЗРЫН ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горим /цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө.

1.2.Горим сонгох, шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт дараах үйл ажиллагаа явуулна:

1.3.1.үзэсгэлэн гаргах;

1.3.2.туршилт хийх;

1.3.3.үйлчилгээ үзүүлэх;

1.3.4.барааны дээж, сорьц, загвар авах;

1.3.5.гаалийн байгууллагаас зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа.

1.4.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хуулийн этгээд хүсэлт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.4, Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасан бичиг баримт, гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байрших бараа тэргүүний техник технологи болохыг тухайн салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлсон албан бичгийг бүрдүүлсэн байна.

1.5.Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтийг гаалийн байгууллага хянахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

1.5.1.тухайн нутаг дэвсгэрт гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар байгаа эсэх;

1.5.2.үйл ажиллагаа явуулж байгаа үзэсгэлэнгийн газрын багтаамж, хүчин чадал, зориулалт нь бараа эргэлтийн ачааллыг дааж байгаа эсэх;

1.5.3.хяналт тавих гаалийн байгууллагын хүний нөөц, үйл ажиллагааны зардалд сөргөөр нөлөөлөх эсэх.

1.5.4.тухайн аж ахуйн нэгж баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхэлж байсан эсэх, Гаалийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.2-т заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл хүчингүй болсноос хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн эсэх.

1.6.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг гаалийн удирдах төв байгууллагын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

1.7.Гаалийн удирдах төв байгууллага Гаалийн тухай хуулийн 138.1.3-т заасан гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж, энэ журмын хавсралтаар батлагдсан загвар бүхий “Зөвшөөрөл” олгоно.

1.8.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгах, зориулалт, талбайн хэмжээ, байршил өөрчлөх, гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлөө хүчингүй болгуулах талаар өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

1.9.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгах, агуулахын зориулалт, агуулахын талбайн хэмжээ, байршил болон төрөл өөрчлөх асуудлыг гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

1.10.Хяналт тавих гаалийн байгууллага нь гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.11.Үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага “Өөрийн үнэлгээний хуудас”-ыг бөглөж, хяналт тавих гаалийн байгууллагаар хянуулж, баталгаажуулалт хийлгэсэн байна.

1.12.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргахдаа энэ журмын 1.10-т заасан гэрээг дүгнүүлэн, “Өөрийн үнэлгээний хуудас”-ыг бөглөж, хяналт тавьдаг гаалийн байгууллагаар хянуулж, баталгаажуулалт хийлгэсэн байна.

1.13.Хяналт тавьж байгаа гаалийн байгууллага нь “Өөрийн үнэлгээний хуудас”-ын дагуу тухайн гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр тус тус “Хангалттай” эсхүл “Хангалтгүй” гэсэн үнэлгээгээр үнэлж, дараа сарын 05-ны өдрийн дотор гаалийн хяналт, шалгалтын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

1.14.Энэ журмын 1.12 дахь хэсэгт заасан үнэлгээгээр “Хангалтгүй” үнэлэгдсэн тохиолдолд хяналт тавьж байгаа гаалийн байгууллагаас гүйцэтгэл сайжруулж, шаардлага хангуулах зорилгоор тодорхой хугацаатай үүрэг өгч биелэлтэд хяналт тавьж ажиллана.

1.15.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар эрхлэх зөвшөөрөл олгосон, зөвшөөрлийн хугацаа сунгасан тухай гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаал батлагдсанаас хойш ажлын 7 хоногт багтаан Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолын хавсралтын 9.1.7-д заасан улсын тэмдэгтийн хураамжийг төлнө.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Үзэсгэлэнд тавигдах техник, тоног төхөөрөмж, бараа материалыг энэ горимд байршуулна.

2.2.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар байгуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмж, бусад барааг энэ горимд байршуулахгүй бөгөөд мэдүүлэгчийн сонгосон бусад горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.3.Горимд байршуулах монголын бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарах бөгөөд гадаадын бараа нь Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.

2.4.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах	720	шаардахгүй
2	Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах	721	шаардахгүй
3	Барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах:		
	- баталгаат үзэсгэлэнгийн газраас	722	720, 723-725
	- гаалийн тусгай бүсээс	723	750-753, 758-765
4	Барааг чөлөөт бүсээс гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах	724	770, 771, 774-778
5	Гаалийн баталгаат агуулахаас гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах	725	700, 703, 704, 706, 707, 709

2.5.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрууд нь нэг эзэмшигчтэй байх тохиолдолд гаалийн бүрдүүлэлтийн горимын 722 кодоор бүрдүүлэлт хийнэ.

2.6.Гаалийн бүрдүүлэлтийн 722-725 горимд гадаадын барааг байршуулна.

Гурав. Гаалийн бүрдүүлэлт

3.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас болон гаалийн баталгаат, чөлөөт бүсээс гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулахад Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

3.2.Гадаадын барааг хилийн чанадаас, гаалийн баталгаат болон чөлөөт бүсээс энэ горимын дагуу гаалийн байгууллагад мэдүүлэхдээ тээврийн бичиг баримт, гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэхийг гаргаж өгнө.

3.3.Горимд байршуулах монголын бараанд гаалийн бүрдүүлэлт хийхэд Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан бичиг баримтыг гаргаж өгнө.

3.4.Журмын 3.2, 3.3-т заасан мэдээлэл, бичиг баримт нь горимын шаардлага хангаагүй бол гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.5.Мэдүүлэгч 3.4-т заасан бичиг баримтыг цахим шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.6.Гаалийн үнийг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу нягтлан шалгана.

3.7.Горимын дагуу байршуулах барааны мэдээллийг хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч гаалийн автоматжуулсан системээр хүлээн авч, бичиг баримттай тулган шалгаж, “Баталгаажуулах” үйлдэл хийж, мэдээллийг гаалийн улсын ахлах байцаагчид гаалийн автоматжуулсан систем ашиглан цахимаар илгээнэ. Хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч “Зөвшөөрөх” үйлдэл хийсэнээр гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болно.

3.8.Мэдүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн мэдүүлгийг хэвлэж гаалийн улсын байцаагч баримтад “Гаалийн хяналтад байгаа” тэмдэг дарж, гаалийн улсын байцаагч гарын үсгээ зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.

Дөрөв. Горимын шаардлага

4.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэгч нь Гаалийн тухай хуулийн 159 дүгээр зүйлд зааснаас гадна дараах нөхцөл шаардлагыг хангасан байна:

4.1.1.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар эрхлэх зөвшөөрөл олгосон тушаалд заасан байршил, нутаг дэвсгэр, талбайд зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулах;

4.1.2.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь хяналт тавих гаалийн байгууллага гэрээ байгуулан ажиллах;

4.1.3.гаалийн байгууллагаас томилогдсон ажилтныг ажлын байр болон ажиллах нөхцлөөр хангах;

4.1.4.зөвшөөрөл бүхий даатгагчтай хариуцлагын даатгалын гэрээ байгуулсан байх;

4.1.5.тухайн үйл ажиллагаанаас эрсдэл үүссэн тохиолдолд гаалийн болон бусад татвар, хураамжийг төлж, барагдуулах санхүүгийн чадавхитай болохоо эрх бүхий аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, дансны хуулгаар нотолсон байх;

4.1.6.тэгш өнцөгт хэлбэртэй 1.0x0.60 метрийн харьцаатай, цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар” гэсэн бичээстэй, зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэг байрлуулсан байх;

4.1.7.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар нь гаалийн нэгдсэн сүлжээнд холбогдож, барааны бүртгэлд GS1 системийг нэвтрүүлсэн байх;

4.1.8.барааг үзэсгэлэнгийн газарт байх хугацаанд гэмтсэн, чанарын шаардлага хангахгүй болсон бол уг барааны мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулж, гаалийн хууль тогтоомжийн дагуу гаалийн бүрдүүлэлт хийлгэх;

4.1.9.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлд заасан байршил, зориулалт, талбайн хэмжээг өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд шинэ талбайн хэмжээ, байрлал, барилга байгууламжийн зургийг холбогдох бусад материалын хамт бүрдүүлэн, гаалийн удирдах төв байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх;

4.1.10.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын барааны бүртгэлийг орсон, гарсан бараагаар хөтөлж, барааны хөдөлгөөний мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 03-ны дотор хяналт тавьдаг гаалийн байгууллагад өгөх;

4.1.11.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байршуулах бараа нь ашиглаж хэрэглээгүй шинэ бараа байх бөгөөд тоо, шинж чанар болон бусад үзүүлэлтээс хамааран тэргүүний техник технологийг судлах, захиалах нөхцөл бүрүүлэх зорилгоор загвар дээж тус бүрээс 1 ширхэгийг тодорхой хугацаанд байршуулах;

4.1.12.барааг загвар, зориулалтаар нь ангилан, шошго тавьж байрлуулах**;**

4.1.13.гаалийн хяналт, бүрдүүлэлтэд шинэ техник, технологи нэвтрүүлж, Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажиллах;

4.1.14.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт бараа ороогүй, хадгалагдаж байгаа бараа байхгүй, үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа явагдаагүй хугацаа нь 6 сар буюу түүнээс дээш хугацаагаар хэтрээгүй байх**;**

4.1.15.хяналт тавьж ажиллах гаалийн байгууллагаас ирүүлсэн “Өөрийн үнэлгээний хуудас” нь 90 буюу түүнээс дээш оноогоор “хангалттай” үнэлэгдсэн байх;

4.1.16.гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хяналтын камерыг бараа, ажил, үйлчилгээ бүхэлдээ харагдах, гаалийн хяналтын шаардлага хангахуйц тоо хэмжээгээр тохирох газарт байрлуулна. Камерын бичлэгийг гаалийн хяналтын зорилгоор ашиглах шаардлага хангахуйц түвшинд хийж, хяналтын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалж, гаалийн байгууллагаас шаардсан хугацаанд гаргаж өгөх.

4.2.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байршуулах барааны онцлог байдлыг харгалзан шаардлагатай бол тусгай нөхцөл шаардлага тавьж болно.

4.3.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагад гаргана.

4.4.Энэ горимд байршуулсан барааг хоёр буюу түүнээс дээш гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс дамжуулан байршуулсан бол гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байршуулах нийт хугацаа нь Гаалийн тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1-д заасан хугацаанаас хэтрэхгүй байна.

4.5.Барааг горимд байршуулах хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө гаалийн удирдах төв байгууллагын холбогдох нэгжид хугацаа сунгуулах хүсэлтийг бичгээр гаргана.

Тав. Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь үзэсгэлэнгийн газарт тавигдах горимын шаардлагыг зөрчсөн дараах тохиолдолд үйл ажиллагааг Гаалийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.1-д заасны дагуу 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно:

5.1.1.энэ журмын 4.1.1 дэх заалт, 4.1.8, 4.1.11, 4.1.14, 4.1.16, 4.4. дахь хэсгийг зөрчсөн;

5.1.2.энэ журмын 1.12 дахь заалтад заасан үнэлгээний хуудсаар хангалтгүй үнэлэгдсэнтэй холбогдуулж, шаардлага хангуулах зорилгоор хяналт тавьж буй гаалийн байгууллагаас өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлээгүй;

5.1.3.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй нэвтрүүлсэн.

5.2.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шалтгаан, зөрчлийг арилгаж шаардлагыг заасан хугацаанд биелүүлсэн тохиолдолд зөвшөөрлийг сэргээх асуудлыг гаалийн удирдах төв байгууллага шийдвэрлэнэ.

5.3.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно;

5.3.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

5.3.2.зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан;

5.3.3.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг засаагүй;

5.3.4.зөвшөөрөл эзэмшигч нь гаалийн тухай хууль тогтоомжийг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн.

5.4.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд энэ журмын 4.3-т заасны дагуу хүсэлт гаргаагүй, гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийг хүчингүй болгуулах хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж, зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.5.Гаалийн баталгаат баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ журмын 5.1, 5.3, 5.4-т заасны дагуу түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд тухайн гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байршиж буй барааг Гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2.-т заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.

5.6.Энэ журмын 5.5-д заасан хугацаанд барааг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулаагүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Гаалийн болон бусад татвар

6.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байршуулах болон тэндээс гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2-137.5, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

6.2.Үзэсгэлэнгийн газрын горимд байршуулсан бараанд дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

6.2.1.давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас алдагдсан, устгагдсан;

6.2.2.энэ журмын 6.2.1-т зааснаас өөр бусад хэлбэрээр гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулсан.

6.3.Энэ журмын 6.2.-т заасан тохиолдолд импортын татварыг Монгол банкны ханшийг үндэслэн, хүчин төгөлдөр мөрдөж буй ердийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ

Долоо. Бусад

7.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байршуулах хугацаа хэтэрсэн барааг Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/276 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан журмын хавсралт

ЗӨВШӨӨРӨЛ

ДУГААР ...

_____

/Хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, оршин буй хаяг/

_____

/Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрөл/

_____

/Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа/

_____

/Гаалийн баталгаат бүсэд эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл шаардлага, код/

_____

/Зөвшөөрлийг олгосон тушаалын дугаар,он, сар,өдөр/

_____

/ гарын үсэг, тамга/

Гэрчилгээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

№	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга, сунгалт	Бүртгэсэн	
		огноо	Гарын үсэг, тамга
1.			
2.			
3.			

Гаалийн ерөнхий газрын даргын
2019 оны А/276 дугаар тушаалын
4 дүгээр хавсралт

ГААЛИЙН БАТАЛГААТ БАРИЛГЫН ТАЛБАЙН
ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гаалийн баталгаат барилгын талбайн горим /цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө.

1.2.Горим сонгох, шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3.Гаалийн баталгаат барилгын талбайд дараах үйл ажиллагаа явуулна.

1.3.1.барилгын материалын бүрэн бүтэн байдлыг шалгах;

1.3.2.барилгын материал боловсруулах;

1.3.3.барилга угсралтын үйл ажиллагаа явуулах;

1.3.4.гаалийн байгууллагаас зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа.

1.4.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, хуулийн этгээд нь хүсэлт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1.-11.1.4, Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасан бичиг баримт, гаалийн баталгаат барилгын талбайд барих барилга байгууламж нь Монгол Улсын эдийн засагт стратегийн чухал ач холбогдол бүхий барилга байгууламж болохыг нотолсон эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулсан байна.

1.5.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагааг Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага холбогдох зөвшөөрлийн дагуу эрхлэн явуулна.

1.6.Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтийг гаалийн байгууллага хянахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

1.6.1.тухайн барилга нь эдийн засагт стратегийн чухал ач холбогдолтой эсэх;

1.6.2.барилга барихад ашиглагдах гадаадын барилгын материалын орц нийт материалын 50-аас дээш хувийг эзэлж байгаа эсэх;

1.6.3.хяналт тавих гаалийн байгууллагын хүний нөөц, үйл ажиллагааны зардалд сөргөөр нөлөөлөх эсэх;

1.6.4.тухайн аж ахуйн нэгж баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхэлж байсан эсэх, Гаалийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.2-т заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл хүчингүй болсноос хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн эсэх.

1.7.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг гаалийн удирдах төв байгууллагын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

1.8.Гаалийн удирдах төв байгууллага Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.1.4.-т заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж, энэ журмын хавсралтаар батлагдсан загвар бүхий “Зөвшөөрөл” олгоно.

1.9.Хяналт тавих гаалийн байгууллага нь гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.10.Барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага “Өөрийн үнэлгээний хуудас”-ыг бөглөж, хяналт тавих гаалийн байгууллагаар хянуулж, баталгаажуулалт хийлгэсэн байна.

1.11.Хяналт тавьж байгаа гаалийн байгууллага нь “Өөрийн үнэлгээний хуудас”-ын дагуу тухайн гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагааг “Хангалттай” эсхүл “Хангалтгүй” гэсэн үнэлгээгээр үнэлэх бөгөөд “Хангалтгүй” үнэлэгдсэн тохиолдолд

гүйцэтгэл сайжруулж, шаардлага хангуулах зорилгоор тодорхой хугацаатай үүрэг өгч биелэлтэд хяналт тавина.

1.12.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон тухай гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаал батлагдсанаас хойш ажлын 7 хоногт багтаан Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолын хавсралтын 9.1.7-д заасан улсын тэмдэгтийн хураамжийг төлнө.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Барилгыг барихад шаардагдах үндсэн болон туслах материалыг Гаалийн тухай хуулийн 167.2.-т заасны дагуу тухайн барилга бүрэн ашиглалтад оруулах хүртэлх хугацаанд энэ горимд байршуулна.

2.2.Тухайн барилгыг барихад ашиглагдах хилийн чанадаас ирсэн техник, тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгслийг энэ горимд байршуулахгүй бөгөөд мэдүүлэгчийн сонгосон бусад горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.3.Горимд байрших гадаадын бараа нь Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.

2.4.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг гаалийн баталгаат барилгын талбайд оруулах	730	шаардахгүй
2	Барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн баталгаат барилгын талбайд оруулах :		
	гаалийн баталгаат агуулахаас	731	700, 703, 704, 706, 707, 709
	баталгаат барилгын талбайгаас	732	730-731, 733, 734
	гаалийн тусгай бүсээс	733	750-753, 758-765
3	Барааг чөлөөт бүсээс гаалийн баталгаат барилгын талбайд оруулах	734	770-771, 774-778

2.5.Гаалийн баталгаат барилгын талбайнууд нь нэг эзэмшигчтэй байх тохиолдолд гаалийн бүрдүүлэлтийн горимын 732 кодоор бүрдүүлэлт хийнэ.

2.6.Гаалийн бүрдүүлэлтийн 730-734 горимд гадаадын барааг байршуулна.

Гурав. Гаалийн бүрдүүлэлт

3.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас болон гаалийн баталгаат, чөлөөт бүсээс гаалийн баталгаат барилгын талбайд оруулах тохиолдолд Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

3.2.Гадаадын барааг хилийн чанадаас, гаалийн баталгаат болон чөлөөт бүсээс энэ горимын дагуу гаалийн байгууллагад мэдүүлэхдээ тээврийн бичиг баримт, гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэхийг гаргаж өгнө.

3.3.Горимд байршуулах монголын барааг бүртгэж хяналт тавина.

3.4.Журмын 3.2 дахь заалтад заасан бичиг баримт нь горимын шаардлага хангаагүй бол гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.5.Мэдүүлэгч 3.2, 3.4-т заасан бичиг баримтыг цахим шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.6.Гаалийн үнийг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу нягтлан шалгана.

3.7.Горимын дагуу байршуулах барааны мэдээллийг хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч гаалийн автоматжуулсан системээр хүлээн авч, бичиг

баримттай тулган шалгаж, “Баталгаажуулах” үйлдэл хийж, мэдээллийг гаалийн улсын ахлах байцаагчид гаалийн автоматжуулсан систем ашиглан цахимаар илгээнэ. Хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч “Зөвшөөрөх” үйлдэл хийсэнээр гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болно.

3.8.Мэдүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн мэдүүлгийг хэвлэж гаалийн улсын байцаагч баримтад “Гаалийн хяналтад байгаа” тэмдэг дарж, гаалийн улсын байцаагч гарын үсгээ зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.

Дөрөв. Горимын шаардлага

4.1.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэгч нь Гаалийн тухай хуулийн 166 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1.гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон тушаалд заасан байршил, нутаг дэвсгэр, талбайд үйл ажиллагаа явуулах;

4.1.2.барилга, байгууламжийг байгуулах тухай Засгийн газрын шийдвэр, газар олголтын тогтоол гаргуулсан байх;

4.1.3.гаалийн байгууллагаас томилогдсон ажилтныг ажлын байр болон ажиллах нөхцөлөөр хангах;

4.1.4.зөвшөөрөл бүхий даатгагчтай хариуцлагын даатгалын гэрээ байгуулсан байх;

4.1.5.тухайн үйл ажиллагаанаас эрсдэл үүссэн тохиолдолд гаалийн болон бусад татвар, хураамжийг төлж, барагдуулах санхүүгийн чадавхитай болохоо эрх бүхий аудитаар баталгаажуулсан сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, дансны хуулгаар нотолсон байх;

4.1.6.тэгш өнцөгт хэлбэртэй 1.0х0.60 метрийн харьцаатай, цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн баталгаат барилгын талбай” гэсэн бичээстэй, зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэг байрлуулсан байх;

4.1.7.гаалийн баталгаат барилгын талбай нь гаалийн нэгдсэн сүлжээнд холбогдож, барааны бүртгэлд GS1 системийг нэвтрүүлсэн байх;

4.1.8.баригдаж буй барилга байгууламж нь байгаль орчны нөлөөллөөс бараа, тээврийн хэрэгслийг хамгаалах боломжтой агуулах, чингэлэгтэй байх**;**

4.1.9.гаалийн баталгаат барилгын талбайд үйлдвэрлэх бүтээгдэхүүний орц, норм хэмжээг гаалийн байгууллагад гаргаж өгнө. Гаалийн байгууллага бүтээгдэхүүний орц, норм хэмжээг хянаж тогтоохдоо мэргэжлийн байгууллагын туслалцаа авах**;**

4.1.10.барааг барилгын талбайд байх хугацаанд гэмтсэн, муудсан, чанарын шаардлага хангахгүй болсон бол уг бараанд мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулж, гаалийн хууль тогтоомжийн дагуу гаалийн бүрдүүлэлт хийлгэх;

4.1.11.гаалийн баталгаат барилгын талбайд орсон барааны орц нормын тооцоог гаргаж мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 03-ны өдрийн дотор хяналт тавьдаг гаалийн байгууллагад өгөх**;**

4.1.12.гаалийн баталгаат барилгын талбайд бараа ороогүй, үйл ажиллагаа явуулахгүйгээр тасралтгүй 6 сар буюу түүнээс дээш хугацаа хэтрээгүй байх**;**

4.1.13.гаалийн хяналт, бүрдүүлэлтэд шинэ техник, технологи нэвтрүүлж, Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажиллах**;**

4.1.14.гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хяналтын камерыг бараа, ажил, үйлчилгээ бүхэлдээ харагдах, гаалийн хяналтын шаардлага хангахуйц тоо хэмжээгээр тохирох газарт байрлуулна. Камерын бичлэгийг гаалийн хяналтын зорилгоор ашиглах шаардлага хангахуйц түвшинд хийж, хяналтын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалж, гаалийн байгууллагаас шаардсан хугацаанд гаргаж өгөх;

4.1.15.хяналт тавьж ажиллах гаалийн байгууллагаас ирүүлсэн “Өөрийн үнэлгээний хуудас” нь 90 буюу түүнээс дээш хувиар “Хангалттай” үнэлэгдсэн байх.

4.2.Гаалийн баталгаат барилгын талбайн онцлог байдлыг харгалзан тусгай нөхцөл шаардлага тавьж болно.

Тав. Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь барилгын талбайд тавигдах горимын шаардлагыг зөрчсөн дараах тохиолдолд үйл ажиллагааг Гаалийн тухай хулийн 140 дүгээр зүйлийн 140.1-д заасны дагуу 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно:

5.1.1.энэ журмын 4.1.1 дэх заалт, 4.1.8, 4.1.10, 4.1.12, 4.1.13, 4.1.14. дэх хэсгийг зөрчсөн;

5.1.2.энэ журмын 1.1.12 дэх заалтад заасан үнэлгээний хуудсаар хангалтгүй үнэлэгдсэн тохиолдолд шаардлага хангуулах зорилгоор хяналт тавьж буй гаалийн байгууллагаас өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлээгүй;

5.1.3.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй нэвтрүүлсэн.

5.2.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шалтгаан, зөрчлийг арилгаж шаардлагыг заасан хугацаанд биелүүлсэн тохиолдолд зөвшөөрлийг сэргээх асуудлыг гаалийн удирдах төв байгууллага шийдвэрлэнэ.

5.3.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараахь тохиолдолд хүчингүй болгоно:

5.3.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

5.3.2.зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан;

5.3.3.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

5.3.4.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гаалийн тухай хууль тогтоомжийг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн.

5.4.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийг хүчингүй болгуулах хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж хүчингүй болгоно.

5.5.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ журмын 5.1, 5.3, 5.4-т заасны дагуу түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд тухайн гаалийн баталгаат барилгын талбайд байршиж буй барааг Гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2.-т заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.

5.6.Энэ журмын 5.5-т заасан хугацаанд барааг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулаагүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Гаалийн болон бусад татвар

6.1.Гаалийн баталгаат барилгын талбайд байршуулах болон тэндээс гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2-137.5, Гаалийн тариф, гаалийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1.-д заасны дагуу шийдвэрлэнэ.

6.2.Барилгын талбайн горимд байршуулсан бараанд дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

6.2.1.давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар гаалийн баталгаат агуулахаас алдагдсан, устгагдсан;

6.2.2.энэ журмын 6.2.1-д зааснаас өөр бусад хэлбэрээр гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулсан.

6.3.Энэ журмын 6.2.-д заасан тохиолдолд импортын татварыг Монгол банкны ханшийг үндэслэн, хүчин төгөлдөр мөрдөж буй ердийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны
А/276 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар
батлагдсан журмын хавсралт

ЗӨВШӨӨРӨЛ

ДУГААР ...

_____

/Хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, оршин буй хаяг/

_____

/Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрөл/

_____

/Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа/

_____

/Гаалийн баталгаат бүсэд эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл шаардлага, код/

_____

/Зөвшөөрлийг олгосон тушаалын дугаар,он, сар, өдөр/

_____

/ гарын үсэг, тамга/

Гэрчилгээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

№	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга, сунгалт	Бүртгэсэн	
		огноо	Гарын үсэг, тамга
1.			
2.			
3.			

Гаалийн ерөнхий газрын даргын
2019 оны А/276 дугаар тушаалын 5
дугаар хавсралт

ТАТВАРГҮЙ БАРААНЫ ДЭЛГҮҮРИЙН ГОРИМ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Татваргүй барааны дэлгүүрийн горим /цаашид горим гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө.

1.2.Горим сонгох, шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3.Мэдүүлэгч горимыг сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

1.4.Гаалийн удирдах төв байгууллага нь Гаалийн тухай хуулийн 138.3-т заасны дагуу сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж, энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан загвар бүхий “Зөвшөөрөл” олгоно.

1.5.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг гаалийн удирдах төв байгууллагын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

1.6.Гаалийн хяналт тавьдаг гаалийн байгууллага нь дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.7.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргахдаа гэрээг дүгнүүлэн, “Өөрийн үнэлгээний хуудас”-аас аль тохирохыг бөглөж, хяналт тавих гаалийн байгууллагаар хянуулж, баталгаажуулалт хийлгэсэн байна.

1.8.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгах асуудлыг гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

1.9.Хяналт тавьж байгаа гаалийн байгууллага нь “Өөрийн үнэлгээний хуудас”-ын дагуу тухайн татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр тус тус “Хангалттай” эсхүл “Хангалтгүй” гэсэн үнэлгээгээр үнэлж, дараа сарын 05-ны өдрийн дотор гаалийн хяналт, шалгалтын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

1.10.Энэ журмын 1.9 дэх хэсэгт заасан үнэлгээгээр “Хангалтгүй” үнэлэгдсэн тохиолдолд хяналт тавьж байгаа гаалийн байгууллагаас шаардлага хангуулж, гүйцэтгэл сайжруулах зорилгоор тодорхой хугацаатай үүрэг өгч биелэлтэд хяналт тавьж ажиллана.

1.11.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон, зөвшөөрлийн хугацаа сунгасан тухай гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаал батлагдсанаас хойш ажлын 7 хоногт багтаан Засгийн газрын 2011

оны 199 дүгээр тогтоолын хавсралтын 9.1.7-д заасан улсын тэмдэгтийн хураамжийг төлнө.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Горимд Гаалийн тухай хуулийн 170.1.1-170.1.6 дахь заалтад зааснаас бусад барааг байршуулна.

2.2.Горимд байршуулах монголын бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарах бөгөөд гадаадын бараа нь Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.

2.3.Нийгмийн аюулгүй байдал, ёс суртахуун, эрүүл ахуй, эрүүл мэнд, хүн, мал, ургамлын хорио цээр, худалдааны тэмдэгт, патент, зохиогчийн эрхтэй холбоотойгоос бусад үндэслэлээр барааг хилийн чанадаас татваргүй барааны дэлгүүрт оруулахад хязгаарлалт тогтоохгүй.

2.4.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Шаардах өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулах	740	шаардахгүй
2	Монголын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулах	741	шаардахгүй
3	Барааг гаалийн баталгаат агуулахаас татваргүй барааны дэлгүүрт оруулах	742	700
4	Барааг татваргүй барааны дэлгүүрээс татваргүй барааны дэлгүүрт шилжүүлэх	743	740-742
5	Зөвшөөрөл нь хүчингүй болсон татваргүй барааны дэлгүүрээс зөвшөөрөл нь хүчинтэй үйл ажиллагаа явуулж буй татваргүй барааны дэлгүүрт оруулах	744	740-743

2.5.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж өөрийн нэг дэлгүүрээс нөгөө дэлгүүрт бараа шилжүүлэхэд 743 кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.6.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчингүй болсон дэлгүүрийн барааг зөвшөөрөл нь хүчинтэй үйл ажиллагаа явуулж буй татваргүй барааны дэлгүүрт оруулахад горимын 744 кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.7.Гаалийн бүрдүүлэлтийн горимын 741 кодоор бүрдүүлэлт хийхэд Монгол Улсад үйлдвэрлэсэн, чанар, стандартын шаардлага хангасан, тохирлын гэрчилгээ бүхий бараа хамаарна.

Гурав. Гаалийн бүрдүүлэлт

3.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас татваргүй барааны дэлгүүрт оруулахад Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

3.2.Барааг энэ горимын дагуу гаалийн байгууллагад мэдүүлэхдээ тээврийн бичиг баримт, гадаад худалдааны гэрээ эсхүл үнийн нэхэмжлэхийг гаргаж өгнө.

3.3.Горимд байршуулах монголын бараанд гаалийн бүрдүүлэлт хийхэд Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт заасан бичиг баримтыг гаргаж өгнө.

3.4.Мэдүүлэгч 3.2-3.3-т заасан бичиг баримтыг цахим шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.5.Журмын 3.2-3.3-т заасан мэдээлэл, бичиг баримт нь горимын шаардлага хангаагүй бол гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.6.Татваргүй барааны дэлгүүрт худалдагдсан барааг барааны нэр, марк, зориулалт, барааны ангиллын кодоор нэгтгэж мэдүүлнэ.

3.7.Татваргүй барааны дэлгүүрт худалдагдсан бараанд бүрдүүлэлтийн горимын 314 кодоор бүрдүүлэлт хийх тохиолдолд гадаадын бараанд хэлцлийн 390 код, монголын бараанд 391 кодыг сонгоно.

3.8.Татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулах барааны гаалийн үнийг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу шалгаж тодорхойлно.

3.9.Горимын дагуу байршуулах барааны мэдээллийг хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч гаалийн автоматжуулсан системээр хүлээн авч, бичиг баримттай тулган шалгаж, “Баталгаажуулах” үйлдэл хийж, мэдээллийг гаалийн улсын ахлах байцаагчид гаалийн автоматжуулсан систем ашиглан цахимаар илгээнэ. Хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч “Зөвшөөрөх” үйлдэл хийсэнээр гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болно.

3.10.Мэдүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн мэдүүлгийг хэвлэж гаалийн улсын байцаагч баримтад “Гаалийн хяналтад байгаа” тэмдэг дарж, гаалийн улсын байцаагч гарын үсгээ зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.

Дөрөв. Горимын шаардлага

4.1.Татваргүй барааны дэлгүүр нь Гаалийн тухай хуулийн 171.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

4.1.1.дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэгч нь сонгон шалгаруулалтад ороходоо барааг тогтмол нийлүүлэх талаар баталгаа гаргуулсан компанитай байгуулсан гэрээний дагуу бараа оруулах;

4.1.2.гадаадын гэрээлэгч компаниа өөрчлөх, эсхүл дахин өөр компанитай гэрээ байгуулах тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагад урьдчилан мэдэгдэж, гэрээгээ хянуулж, бүртгүүлсэн байх;

4.1.3.зөвшөөрөл олгосноос хойш 3 сарын дотор үйл ажиллагаагаа эхлүүлсэн байх;

4.1.4.хилийн боомт дахь гарах урсгалд байгаа дэлгүүр нь хилийн чанадад зорчиж буй зорчигчдод зорчигчийн гадаадад зорчих тийз, гадаад паспорт, үндэслэн үйлчлэх;

4.1.5.гаалийн нутаг дэвсгэрийн гүнд байрлах дэлгүүр нь Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтнуудад гаалийн удирдах төв байгууллагаас гаргаж өгсөн нэрсийн дагуу, паспорт эсхүл дипломат үнэмлэхийг үндэслэн үйлчлэх;

4.1.6.гадаад улсаас Монгол улсад суугаа өргөмжит консул татваргүй барааны дэлгүүрээр үйлчлүүлэх эрхгүй;

4.1.7.Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын захиалгаар тусгай үйлчилгээ явуулах тохиолдолд холбогдох нот бичиг, албан ёсны хүсэлтийг худалдан авах барааны тоо хэмжээтэй жагсаалтын хамт хяналт тавьж буй гаалийн байгууллагад ирүүлнэ. Хяналт тавьж буй гаалийн байгууллага бичиг баримтыг хянаж, худалдахыг зөвшөөрөх;

4.1.8.хилийн боомтод гарах урсгалд ажилладаг дэлгүүр зорчигчдод архи, дарс тус бүр 2 литр, шар айраг 3 литр**,** янжуур тамхи 200 ш, сигар 50 ш, үнэртэй ус 0,250 л ба сүрчиг 50 гр худалдах;

4.1.9.гаалийн нутаг дэвсгэрийн гүнд байрлах дэлгүүр нь Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтны хувийн хэрэглээнд архи, дарс тус бүр 2 литр, шар айраг 3 литр, үнэртэй ус 0,250 л ба сүрчиг 50 г, янжуур 200 ширхэг, сигар, навчин тамхи 50 ширхэг, задгай тамхи 250 граммаас илүүгүй хэмжээгээр худалдаалах;

4.1.10.орох урсгалд байрлах татваргүй барааны дэлгүүрийн бараанаас зорчигчид архи, дарс, шар айргийг “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-д гаалийн болон бусад албан татваргүй оруулахаар заасан тоо хэмжээгээр худалдаалах;

4.1.11.татваргүй барааны дэлгүүрт энэ журамд зааснаас өөрөөр, захиалгаар, загварын, зээлийн, нэмэгдэл үйлчилгээний /борлуулалтын өмнөх бэлтгэл ажил, баглах, боох, үзүүлэн таниулах, дахин савлах г.м. үйлчилгээнээс бусад/ болон хаягаар үйлчлэх замаар худалдахыг зөвшөөрөхгүй.

4.1.12.барааны үнийг үндэсний валютаар тогтоох бөгөөд гадаад валютаар худалдаалах тохиолдолд Монголбанкнаас зарласан тухайн өдрийн албан ханшийг баримтлах;

4.1.13.дэлгүүр нь бараа худалдан авсан үйлчлүүлэгчдэд энэ журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан загвар бүхий тод хэвлэсэн кассын талон олгоно. Кассын талон нь үйлчлүүлэгчийн нэр, дипломат үнэмлэхийн дугаар, паспортын болон нислэгийн тийзний дугаар, иргэний харьяалал, хүрэх улс, үйлчлүүлсэн он, сар, өдөр, цаг, минут, худалдан авсан барааны тоо, хэмжээ, үнэ, зураасан болон бусад төрлийн код зэрэг мэдээллийг багтаасан байна;

4.1.14.татваргүй барааны дэлгүүр нь гаалийн байгууллагатай гаалийн нэгдсэн онлайн сүлжээнд холбогдож, барааны бүртгэлд GS1 системийг нэвтрүүлсэн байх;

4.1.15.татваргүй барааны дэлгүүрт орсон, гарсан, үлдэгдэл барааны сар бүрийн мэдээг холбогдох нотлох баримтын хамт дараа сарын 03-ны дотор батлагдсан маягтын дагуу гаргаж, хяналт тавьж буй гаалийн байгууллагад өгөх;

4.1.16.мэдээ тайлан, баримтуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу архивын нэгж болгон боловсруулж хадгалах;

4.1.17.дэлгүүрийн барааны шошго эсхүл хайрцаг дээр “Mongolian duty not paid” гэсэн энэ журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан загвар бүхий дахин салгах боломжгүй дардастай байх;

4.1.18.татваргүй барааны дэлгүүрийн бараг төрөлжүүлэн ангилж, барааны үнийг тавьсан байх;

4.1.19.дэлгүүрийн агуулахад байгаа бараг төрөлжүүлэн хураж, нэр, төрөл, тоо хэмжээ, гаалийн мэдүүлгийн R дугаар, барааны үлдэгдэл, огноог бичсэн шошго тавьсан байх;

4.1.20.барааны хадгалалтын хугацаа дууссан тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн бараг устгах горимд байршуулах;

4.1.21.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хадгалагдаж байгаа барааны чанар, бүрэн бүтэн байдлыг хангах;

4.1.22.хяналт тавьж ажиллах гаалийн байгууллагаас ирүүлсэн “Өөрийн үнэлгээний хуудас” нь 90 буюу түүнээс дээш хувиар “Хангалттай” үнэлэгдсэн байх;

4.1.23.татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэгч нь зөвшөөрөлд заасан хот, боомтод дэлгүүрийн байршлаа өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд шинэ талбайн хэмжээ, байрлал, барилга байгууламжийн зургийг холбогдох бусад материалын хамт бүрдүүлж, гаалийн удирдах төв байгууллагад мэдэгдэж хянуулсан байх;

4.1.24.хяналтын камерыг дэлгүүрийн бараа, үйлчилгээ бүхэлдээ харагдах, гаалийн хяналтын шаардлага хангахуйц тоо хэмжээгээр тохирох газарт байрлуулах;

4.1.25.гаалийн хяналтын зорилгоор ашиглах шаардлага хангахуйц камерын бичлэгийг хяналтын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалж, гаалийн байгууллагаас шаардсан хугацаанд гаргаж өгөх;

4.1.26.татваргүй барааны дэлгүүрт худалдагдсан бараг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгож нэгтгэн, дараа сарын 05-ны дотор гадаадын бараг гаалийн бүрдүүлэлтийн горимын 314, монголын бараг гаалийн бүрдүүлэлтийн горимын 145 кодоор гаалийн байгууллагад мэдүүлж, бүрдүүлэлт хийлгэх;

4.1.27.энэ журмын 4.1.8-4.1.10, 4.1.12 дахь заалтад заасан зорчигчдод татваргүй нэвтрүүлэх барааны тоо хэмжээ, валютын ханш болон энэ журмын талаар үйлчлүүлэгчид таниулан сурталчлах зорилгоор англи, монгол хэл дээр бэлтгэсэн танилцуулга, гарын авлага, бусад мэдээллийг дэлгүүрт байрлуулсан байх;

4.1.28.зөвшөөрөл бүхий даатгагчтай хариуцлагын даатгалын гэрээ байгуулсан байх;

4.1.29.татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагад гаргасан байх.

Тав. Татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь дэлгүүрт тавигдах нөхцөл, шаардлага зөрчсөн дараах тохиолдолд үйл ажиллагааг Гаалийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.1-д заасны дагуу 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ**:**

5.1.1.энэ журмын 4.1.3, 4.1.5-4.1.7, 4.1.11, 4.1.23-4.1.24 дэх заалтыг зөрчсөн;

5.1.2.энэ журмын 1.9 дэх заалтад заасан үнэлгээний хуудсаар хангалтгүй үнэлэгдсэн тохиолдолд шаардлага хангуулах зорилгоор хяналт тавьж буй гаалийн байгууллагаас өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлээгүй;

5.1.3.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй нэвтрүүлсэн.

5.2.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шалтгаан, зөрчлийг арилгаж, шаардлагыг заасан хугацаанд биелүүлсэн тохиолдолд зөвшөөрлийг сэргээх асуудлыг гаалийн удирдах төв байгууллага шийдвэрлэнэ.

5.3.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

5.3.1.татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

5.3.2.татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрөл авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн болох нь тогтоогдсон;

5.3.3.татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан;

5.3.4.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг засаагүй;

5.3.5.гаалийн хууль тогтоомжийг 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн;

5.3.6.татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг энэ журмын 4.1.29 дэх хэсэгт заасан хугацаанд гаргаагүй.

5.4.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд энэ журмын 4.1.29-д заасны дагуу хүсэлт гаргаагүй, татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийг хүчингүй болгуулах хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж, зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.5.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ журмын 5.1, 5.3, 5.4-т заасны дагуу түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдолд үлдэгдэл барааг тоолж, зөвшөөрөл ньтүдгэлзсэн, хүчингүй болсон дэлгүүрийн байр, агуулахад гаалийн хяналтан дор хадгална. Энэ тохиолдолд барааг гаалийн түр агуулахад байгаад тооцно.

5.6.Энэ журмын 5.5-т заасан барааг гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн холбогдох горимд байршуулна.

5.7. Энэ журмын 5.6-д заасан хугацаанд барааг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулаагүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Гаалийн болон бусад татвар

6.1.Татваргүй барааны дэлгүүрт байршуулах болон тэндээс хилийн чанадад гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2-137.5 дахь хэсэг, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтад заасны дагуу шийдвэрлэнэ.

6.2.Татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулсан бараанд дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

6.2.1.давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар татваргүй барааны дэлгүүрээс алдагдсан, устгагдсан;

6.2.2.энэ журмын 4.1.4-4.1.5-д зааснаас бусад этгээдэд худалдан борлуулсан;

6.2.3.энэ журмын 6.2.1-6.2.2-т зааснаас өөр бусад хэлбэрээр гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулсан.

6.3.Энэ журмын 6.2-д заасан тохиолдолд импортын татварыг Монгол банкны ханшийг үндэслэн, хүчин төгөлдөр мөрдөж буй ердийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/276 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан журмын 1 дүгээр хавсралт

ЗӨВШӨӨРӨЛ

ДУГААР ...

/Хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, оршин буй хаяг/

/Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрөл/

/Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа/

/Гаалийн баталгаат бүсэд эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл шаардлага, код/

/Зөвшөөрлийг олгосон тушаалын дугаар, он, сар, өдөр/

/ гарын үсэг, тамга/

Гэрчилгээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

№	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга, сунгалт	Бүртгэсэн	
		Огноо	Гарын үсэг, тамга
1.			
2.			
3.			

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны
А/276 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар
батлагдсан журмын 2 дугаар хавсралт

ТАТВАРГҮЙ БАРААНЫ ДЭЛГҮҮРЭЭС БАРАА ХУДАЛДАН АВСНЫГ
НОТЛОХ КАССЫН ТАЛОНЫ ЗАГВАР

SALES SLIP № _____

Date and time_____ _____

Name _____
_____

Citizenship_____Country of destination
_____

Card and passport №_____Travel №_____

Ticket № _____Seat №_____

Code Description of goods Quantity
Amounts